



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 01 сарын 19 өдөр

Дугаар А/40

Булган

Халдвараас урьдчилан сэргийлэх
арга хэмжээ авах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.2, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 385, 2022 оны 01 дүгээр тогтоол, Засгийн газрын 2022 оны 03 дугаар хуралдааны тэмдэглэл, Улсын Онцгой комиссын 2022 оны 01 дүгээр хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улс, орон нутагт коронавируст халдварын Омикрон хувилбар тархаж байгаатай холбогдуулан эрсдэлээс урьдчилан сэргийлж Монголын уламжлалт Цагаан сарын баярыг гэр бүлийн хүрээнд тэмдэглэн өнгөрүүлэхийг нийт ард иргэдэд уриалсугай.

2. Аймгийн хэмжээнд 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдрөөс 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрийг дуустал олон нийтийг хамарсан бүх төрлийн тэмцээн уралдаан, соёл урлаг, хурал цуглааны үйл ажиллагааг заал, танхимын 50 хувийн дүүргэлттэйгээр коронавируст халдвар /Ковид-19/-ын эсрэг дархлаажуулалтын 3, 4 дүгээр тунгийн хамрагдалт, коронавирусын халдварын шинжилгээний хариуг харгалзан халдвар хамгааллын дэглэмийг баримтлан зохион байгуулахыг зөвшөөрсүгэй.

3. Коронавируст халдвар /Ковид-19/-ын мутацилагдсан шинэ хувилбарын тархалтаас урьдчилан сэргийлэх, халдварын эсрэг дархлааны түвшинг нэмэгдүүлэх зорилгоор дархлаа сэргээх нэмэлт тунд иргэдийг идэвхтэй хамруулах ажлыг зохион байгуулж ажиллахыг Эрүүл мэндийн газар (С.Нарантуяа), сумын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

4. Ажлын байранд коронавируст халдвар /Ковид-19/ тархах, хүний нөөцийн дутагдалд орохоос урьдчилан сэргийлж 0-5 насны хүүхэдтэй эцэг, эх гэрээсээ, цахимаар ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлж ажиллахыг бүх шатны төсвийн байгууллагын дарга, захирал, эрхлэгч нарт даалгаж, хувийн хэвшлийн байгууллагын ажил олгогч нарт зөвлөсүгэй.

Doc/2022/Захирамж


20220048

5.Мал амьтны гоц халдварт шүлхий өвчний эрсдэл өндөр байгаатай холбогдуулан отор, нүүдэл, малын шилжилт хөдөлгөөн, мал, махны тээвэрлэлтэд хяналт тавьж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүх шатанд хэрэгжүүлж ажиллахыг Цагдаагийн газар, (цагдаагийн хурандаа Л.Ганбаатар), Мал эмнэлгийн газар (Г.Одсүрэн) сумын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

6.Коронавируст халдвар /Ковид-19/ болон малын гоц халдвартай шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх шаардлагатай мэдээ мэдээллийг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран тогтмол бэлтгэж бүх сувгаар олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Эрүүл мэндийн газар (С.Нарантуяа), Мал эмнэлгийн газар (Г.Одсүрэн), аймгийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах алба (Г.Алтанцэцэг), сумын Засаг дарга нарт тус тус даалгасугай.

7.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Алтаншагай, Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Ш.Баасандорж нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ